



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	3
1.3. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	4
1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар.....	4
1.5. Хяналт шалгалтын талаар	5

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар.....	6
2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	6
2.3. Стандарт, нормативын чиглэлээр	7

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

8

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

8

4.1. Авто замын талаар	8
4.2. Авто тээврийн талаар	9
4.3. Төмөр замын талаар	10
4.4. Агаарын тээврийн талаар	11

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

12

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 10 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тус яаманд 2018 оны 09 дүгээр сард нийт 745 бичиг ирснээс хариутай 309 бичиг, хариугүй 436 бичиг, шийдвэрлэсэн 180 нийт 11627.5 хуудас бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд орууллаа.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-141, Төрийн захиргааны удирдлагын газарт-180, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-122, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-54, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-89, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэст-47, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-102 бичиг шилжүүлсэн байна. Яамнаас гадагш 503 албан бичиг явуулж 3171 хуудас сканердаж able программд оруулсан.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар-114, Төрийн захиргааны удирдлагын газар-125, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 85, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-46, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-66, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-34, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-33 албан бичиг тус тус явуулсан байна.

1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. 2018 оны 09 дүгээр сарын 01-30-ны байдлаар яамны хэмжээнд иргэд, албан хаагчдаас нийт 47 өргөдөл, гомдол ирсэнийг удирдлагад танилцуулан цохолт хийлгүүлж холбогдох албан тушаалтанд хуваарилан ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 38, хяналтад байгаа 9, гомдол, шийдвэрлэлтийн хувь 82.61 хувьтай байна. Дээрх өргөдөл, гомдол нь ээлжийн амралт олгуулах, цалинтай, цалингүй чөлөө хүссэн зэрэг агуулгатай байна. Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Төсвийн тухай хуулийн 8, 29.4-т заасны дагуу саналаа ирүүлсэн Нийслэл, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Хэнтий, Ховд, Увс, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь зэрэг 21 аймаг, Иргэний нисэхийн ерөнхий газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Далайн захиргаа, “МТЗ” ТӨХК, Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудын ирүүлсэн төсвийн төслийн саналыг хянан боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын 2019 оны төсвийн төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/3822, 02/3939, 02/4343 тоот албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг 09 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсын дагуу захиалан тарааж байна. 09-р сарын 30-ны байдлаар бичиг хэргийн зардал 20,772,425.00 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 9,338,938.0 төгрөг, Шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 14,762,370.69 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна. Мөн бусад техник хэрэгслээр цаг тухай бүр ханган ажиллаж байна.

Яамны хөрөнгө оруулалтын 2017 оны санхүүгийн тайланг гаргаж, сайдын багцын тайланд нэгтгүүлж, Үндэсний аудитын газраар шалгуулан зөрчилгүй дүгнэлт авсан. 2018 оны 09 дүгээр сарын 30-ны улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 20 төсөл, арга хэмжээний 15,639.7 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 23 төсөл, арга хэмжээний 6,763.1 сая төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст сар бүр тогтсон хугацаанд нийгмийн даатгалын тайланг гарган тушааж байна. Албан хаагчдын жирэмсний тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцоог гаргаж, нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн, дансанд орсон тухай бүр албан хаагчдад тооцож олгож байгаа болно.

1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

Дараах чиглэлээр 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Үүнд:

- УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлт,
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт,
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2087 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт,
- Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт,

- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний биелэлт,
- Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөө, хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт,
- Яамны үйл ажиллагааны болон хүний нөөцийн бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлт,
- Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2016-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт,
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,
- Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод бүтцийн нэгжүүдийн дарга/менежер/ нарын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг болно.

1.6. Хяналт шалгалтын талаар:

Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдын баталсан 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн удирдамжийн дагуу ажлын хэсэг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замын засвар арчлалтын өнөөгийн нөхцөл байдлыг газар дээр нь очиж ажилласан. Тус яамны 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Замын засвар арчлалтын тухай 02/4663 тоот албан бичгийг УУХҮЯ, ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 15-ны өдрийн хооронд Ховд аймгийн Хөшөөт нүүрсний уурхайгаас улс хоорондын ачаа тээвэрлэгч 19 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Нийслэлийн Тээврийн газар болон Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-тай байгуулсан Автотээврийн хяналтын чиглэлээр 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөг тус тус үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Зөвлөн туслах үйлчилгээний удирдамжийн дагуу 2018 оны 09 дүгээр сарын 24-өөс 2018 оны 10 дугаар сарын 02, 2018 оны 10 дугаар сарын 15-аас 2018 оны 10 дугаар сарын 19-ны өдрүүдэд Авто үйлчилгээ (засвар) Улаанбаатар хотод 100, орон нутагт 100 нийт 200 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.

Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдын баталсан “Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг шалгах” хуваарийн дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын зорчигч тээврийн болон техникийн хяналтын салбарууд, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Лотот” ХХК, “УБ глоб транс” ХХК, “Ач буян трэвел” ХХК, “Л-Ч” ХХК-уудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Салбарын харъяа байгууллагуудад хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, түүнд тавигдах хяналтыг сайржуулах, зам, даваа хаагдах үед шуурхай арга хэмжээ авч ажиллах, техникийн бэлэн байдлыг хангуулах тухай 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10/4558 тоот албан бичгийг боловсруулан, хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны Зам, тээврийн хяналтын хэлтсийн 2018 оны төлөвлөгөө, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай байгуулсан “Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах хамтран ажиллах гэрээ”-ний 4.2.3 дах заалтыг үндэслэн Хот хоорондын нийтийн зорчигч тээвэр эрхлэгч 59 байгууллагын хагас жилийн хугацаанд хэрэгжүүлсэн “дотоод хяналт шалгалт”-ын тайланд дүн шинжилгээ хийсэн. Тайлангийн дүнг үндэслэн 39 байгууллагад Дотоод хяналт шалгалт сайжруулах тухай улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 181 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд салбар тус бүрээр нийт 40 арга хэмжээ төлөвлөсөн. Хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд газар дээр нь очиж шалгасан. Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил **77.0** хувьтай байна. Гол ажлууд 10 дугаар сард хийгдэх бөгөөд одоогоор бэлтгэл хангах шатанд явж байна.

Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 38-07-003,076/41 дугаартай удирдамжийн дагуу Нийслэлийн тээврийн газрын Техникийн хяналтын үзлэгийн төвийн үйл ажиллагаанд 2018 оны 09 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд хяналт шалгалт хийж, 38-07-003,076/50 дугаартай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар:

Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх нийт 16 журмын төслийг боловсруулах ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 дүгээр тушаалаар байгуулсан. Дээрх журмуудаас 1 журмын төсөл буюу “Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийх, үр дүнг боловсруулах журам”-ыг батлуулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд нийт 15 журмын төсөл боловсруулах ажлын явц 9 дүгээр сард дараах байдалтай байна. Үүнээс 6 журам батлагдаж, 7 журам батлагдах шатандаа, 2 журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

Засгийн газарт холбогдох “Ашид арвин буян” ХХК-ийн “Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах ОУ-ын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой МУ-ын ЗГ-ын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өргөрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүх 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хуралдаж, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн үндэслэлийг хууль зүйн үндэслэлгүй болохыг тайлбарласнаар нэхэмжлэгч шууд эвлэрэх хүсэлт гаргасан тул эвлэрэн хэлэлцэхээр болов.

“Хурдны зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний нисэхийн ерөнхий газарт холбогдох “Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг гүйцэтгэх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс 2014, 2015, 2016, 2017 онуудад асфальтобетон заводаа ажиллуулж олох байсан 4 705 118 456 37 /дөрвөн тэрбум долоон зуун таван сая нэг зуун арван найман мянга зуун тавин зургаан төгрөг, гучин долоон мөнгө/ төгрөгний хохиролыг ИНЕГ-аас гаргуулах тухай” нэхэмжлэлтэй иргэний хэрэгт гуравдагч этгээдээр оролцож,

нэхэмжлэлийн шаардлагыг үгүйсгэж, 400, 000,000 /дөрвөн зуун сая/ төгрөг гаргуулахаар шийдвэрлүүлэв.

“Пик девломент” ХХК-ийн нэхэмжлэлтэй Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох “Мөрөн-Тариалан чиглэлийн 29,3 км хатуу хучилттай автозамын зураг төсөвт зааснаас өөрчлөгдсөн тул үнийн өсөлтийн зөрүүг Зам, тээврийн хөгжлийн яамнаас 3.620.082.820 төгрөг болон улсын тэмдэгтийн хураамж 18.258.364 төгрөгийг гаргуулах тухай” нэхэмжлэлтэй иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр оролцож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгуулав.

Зам, тээврийн хөгжлийн яамыг төлөөлж Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн Анхан шатны шүүхэд “Аваргас” ХХК-ийн захирал Г.Чинбатад холбогдуулан “Хархорин-Хужирт” чиглэлийн 36,8 км хатуу хучилттай авто замын хоёрдугаар хэсэг 15,4 км замын барилгын ажил”-ыг гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 276,000,000 /хоёр зуун далан зургаан сая төгрөг /-ийг гаргуулах тухай” нэхэмжлэлийг гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалахаар ажиллаж байна.

2.3. Стандарт, нормативын чиглэлээр:

“Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай болон эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-т нэгдэн орох хуулийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулахаар Гадаад хэргийн яаманд 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/4641 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 97 дугаар захирамжийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 146 дугаар тушаалаар байгуулагдсан салбар комисс нь авто замын 255, авто тээврийн 112, төмөр зам, далайн тээврийн 151, иргэний нисэхийн 27, нийт 545 үндэсний стандартад үзлэг хийж, салбар комиссын нэгдсэн хуралдааныг 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу зам, тээврийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа үндэсний стандартын үзлэгийн 157 хуудас бүхий тайланг Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн аргачлал, зааврын дагуу хийж, 2018 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 3/4666 тоот албан бичгээр төв комисст хүргүүлэв.

Зам, тээврийн сайдын 2016 оны 186 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулж батлуулсан “Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 заалтыг үндэслэн Захиргааны хэм хэмжээний актын Улсын бүртгэлийн 200 дугаарын бүртгэлээс хасуулах саналыг 2018 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 3/466 тоот албан бичгээр хүргүүлэв.

“Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйн хэмжих хэрэгсэл, ажлын болон хяналтын загварууд. Баталгаажуулалтын арга хэрэгсэл” MNS 5842: 2008 стандартыг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд 04/3626 тоот албан бичгээр холбогдох 9 байгууллагаас уг стандартын төсөлд санал авахаар хүргүүлсэн. Стандартын төсөлд ирүүлсэн саналуудыг судлан, тусгах тухай 2018 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 04/4533 тоот албан бичгээр хамтран боловсруулагч байгууллага “УБТЗ” ХНН рүү хүргүүлээд байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Автотээврийн салбарт төрөөс баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс саналыг авч, холбогдох саналуудыг тусган “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 31 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 1/4226 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажилд нэмж шаардагдах хөрөнгийг тус төслийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд шийдвэрлэх, Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын барилгын ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх арга хэмжээг авах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон танилцуулгын боловсруулж, холбогдох яамдаас саналыг авч Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 284 дүгээр тогтоол гарсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 215 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан.

Монгол Улсын агаарын зайн ангилал болон нисэх буудлуудын хяналттай агаарын зайн ангиллыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Агаарын зайн ангиллыг шинэчлэн тогтоох тухай” 202 дугаар тушаалаар, Үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замын үндсэн цэгийн нэрийн өөрчлөлт, дээд ба доод агаарын замын үндсэн цэг болон солбицлын өөрчлөлтийг мөн өдрийн “Үндсэн цэгүүдийн нэр болон солбицол өөрчлөх тухай” 203 дугаар тушаалаар тус тус батлуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газраас ирүүлсэн “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайджан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хянаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Гадаад харилцааны яаманд 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 02/4693 тоот албан бичгээр хүргүүлээд байна.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Авто замын талаар:

Азийн хөгжлийн банкнаас 2018 оны 09 дүгээр сарын 24-29-ний өдрүүдэд Монгол Улсад ирж ажилласан АХБ-ны МОН-3679 зээл, ТА-9544 техник туслалцаагаар хэрэгжих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийг хянах болон мөн төслийн 2 дугаар шатны төслийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлох, тандан судалгаа хийх томилолтын багтай хамтран ажиллаж, төслийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай асуудал тус бүрээр нэгдсэн ойлголтод хүрч, цаашид авах арга хэмжээг тодорхойлон Азийн хөгжлийн банк, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам хамтарсан Харилцан ойлголцлын санамж бичгийг 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр байгуулав. Энэ хүрээнд мөн 2 дугаар шатны төслийн хүрээнд

хэрэгжүүлэхээр санал болгож буй Улаанбаатар-Өвөрхангай чиглэлийн авто замын ашиглалтын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, орон нутгийн удирдлага, авто замын засвар арчлалтын байгууллагуудтай уулзалт зохион байгуулан ажиллав.

Ажлын явц нь батлагдсан график төлөвлөгөөнөөс хоцрогдолтой буюу удаашралтай байгаа авто зам, гүүрийн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, гүйцэтгэгч компани шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу барилгын ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Үерийн улмаас эвдэрсэн олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийг сэргээн засварлах тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 214, ургац тээврийн болон улсын чанартай авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс гарсан эвдэрлийг яаралтай засварлах тухай Зам, тээврийн сайдын 2018 оны 213 дугаар тушаалыг батлуулж, засварын ажлыг гүйцэтгүүлсэн.

Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн 2018 оны урсгал засвар арчлалтын ажлын төлөвлөгөөний биелэлт 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 85%-тай хэрэгжиж байна. Урсгал засвар, арчлалтын ажлын хэрэгжилтэд “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ болон яамны бүс нутаг хариуцсан мэргэжилтэнгүүд хяналт тавин ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Төв аймгийн Зуунмод сумын 0.76 км авто замын барилга, Хөвсгөл аймгийн Ханх-Монд чиглэлийн 23 км авто замын барилга, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 4.5 км авто замын шинэчлэлт, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Галын голын 36 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлыг тус тус улсын ашиглалтад хүлээн авсан.

Улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа авто зам, гүүрийн барилгын ажлуудын мэдээг 7 хоног бүр гаргаж, яамны удирдлагуудад шуурхай хурал зөвөлгөөн дээр танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

4.2. Автотээврийн талаар:

Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 192 дугаар тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр 2018 оны 03/4422 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Тээврийн аюулгүй байдал - Үндэсний тээврийн сүлжээг олон улсын тээврийн сүлжээнд нэгтгэх гарц” болон “Тээврийн төлөвлөлт – Бүсчлэл – Тээврийн төрлүүдийн нэгдмэл байдлыг хангах” чиглэлээр чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцааны төслийн саналыг Европын хөрөнгө оруулалтын банканд тавьсан. Ази номхон далайн олон нийтийн салбарын гадаад хамтын ажиллагаа хариуцсан захирал Анжела Маркаринотай төслийн асуудлаар 2018 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр уулзсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 15, 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Ерөнхий сайдын ажлын алба, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран “Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулав.

“МОН-30 загварын их багтаамжийн цахилгаан автобус нийлүүлэх, туршилт хийх” №130 дугаар гэрээ, №171 дүгээр нэмэлт гэрээний дагуу МОН-30 загварын их багтаамжийн 2 ширхэг цахилгаан автобусыг хүлээн авах, хүлээлгэн өгөх, нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилт хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах техникийн комиссыг Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 317 дугаар тушаалаар байгуулав.

“Тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 144, 174 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдгийн үйлдвэрлэл эрхлэх гэрээ”-г “Төгрөг дугаар” ХХК, “Тэнүүн интерьер дизайн” ХХК, “Өнгөт тэнгэр” ХХК-уудтай, “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх гэрээ”-г “Мөнх ерөөлт интернэйшнл” ХХК-тай тус тус байгуулав.

4.3.Төмөр замын талаар:

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд Ажлын хэсгийн гишүүдэд Албан даалгавар хүргүүлж, Олон улсын төмөр замын байгууллагуудад авч хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж, Монгол Улсын онцлогыг харгалзан Төмөр замын тээврийн салбарын бүтцийн оновчтой хувилбаруудыг тодорхойлох чиглэлээр ажиллаж байна.

Усан замын тээврийн тухай хуульд заасан “Усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник-ашиглалтын дүрэм”-ийн төслийг эцэслэн боловсруулж, сайдын тушаалын төсөл боловсруулаад байна.

Усан замын тээврийн тухай хуульд заасан “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр” -ийн төсөлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналыг тусгаж эцэслэн боловсруулав.

“Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн ложистикийн төвийн дохиолол, холбооны тоног төхөөрөмжийн суурьлуулалтын ажлын гүйцэтгэл хангагдаж тохиргоо, туршилтын ажлууд хийгдэж байна. Мөн тоног төхөөрөмж турших, тохируулга хийхтэй холбоотой дадлага сургалт, дохиолол холбооны тоног төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулж, холбогдох механик болон дохиолол холбооны инженерүүдийг хамруулаад байна.

Монгол-Тяньжины Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны ажлын хэсгийн 8 дугаар хуралдаан Улаанбаатар хотноо 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж, “Тяньжин тээвэр ложистикийн төв төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Тяньжины талтай хуралдааны протокол байгуулж, Тяньжин хотын Дунзян чөлөөт боомтын бүсэд байрлах 10 га газарт хамтарсан тээвэр, ложистикийн төв байгуулах төслийг урагшлуулсан.

Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл хүссэн 3 ААН-ийн өргөдлийг шийдвэрлүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 198 дугаар тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгосон.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 2 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Сайдын 196, 2018 оны 09 дүгээр сарын 17-ний өдрийн 207 дугаар тушаалаар тус тус шийдвэрлэсэн.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 4 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн сайдын тушаалаар шийдвэрлүүлэхээр Ажлын хэсгийн дүгнэлт гарсан.

4.4. Агаарын тээврийн талаар:

Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог Сангийн сайд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар Сангийн яаманд 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 02/4638 тоот албан бичгээр хамтарсан тушаалын төсөл болон бүтэц, орон тооны талаарх саналыг хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 199 дүгээр тушаалаар Монгол-Солонгосын агаарын харилцааны талаар уулзалт хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчилэн баталсан. Ажлын хэсгийг 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хуралдуулж төлөвлөгөөний төсөл, өмнөх ажлын хэсгийн хийж гүйцэтгэсэн ажлууд болон хоёр улсын хоорондын агаарын харилцааны хэлэлцээрийн талаар танилцуулгыг хийсэн.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад хүмүүнлэгийн тусламжаар хонь олгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А-150 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд хүлээн авах албан захиалгат нислэгтэй холбоотой нислэгийн зөвшөөрөл авах, хамгаалагдсан бүсэд нэвтрэх болон газрын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг 2018 оны 09 сарын 18-ны өдрийн 03/4508 тоот албан бичгээр Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсэн.

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулахад Зам, тээврийн хөгжлийн яамны төвшинд авах арга хэмжээний төлөвлөгөө”-г Зам, тээврийн хөгжлийн дэд сайд баталж Үндэсний хөгжлийн газар болон, Иргэний нисэхийн ерөнхий газарт 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 03/4390 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн ажлын явц, тулгамдаж буй асуудлуудын талаар 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ЗТХЯ, ИНЕГ, НБУГ, УБХОУШНБАӨЗА, УБХШНОБбарих төсөл хэрэгжүүлэх нэгж, “Ви Эйч энд Би” ХХК, “Мицүбиши-Чиёода хамтарсан түншлэлийн төлөөллүүдийг оролцуулан хурал зохион байгуулсан. Хурлаар төсөлтэй холбоотой тулгамдаж буй зарим асуудлыг хэлэлцэж тодорхой шийдэлд хүрсэн.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Төв болон Зүүн Азийн газрын дарга Фүжия Кожи-ийг хүлээн авч уулзаж хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон.

Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Стандарт, нормативын хэлтсийн дарга Ж.Сэрээтэр Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын дарга Эдимон Гинтинг-ийг хүлээн авч хоёр талын уулзалт хийсэн.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаан 2018 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд энэхүү хуралдаанд тус яамны холбогдох удирдлагууд оролцсон.

Бельги Улсын Брюссель хотноо 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Бүс нутгийн тээврийн холбоосууд болон царигийн асуудлаар зөвлөгөөнд тус яамны холбогдох удирдлагууд оролцсон.

Нэгдсэн үндэстний байгууллагын Бүсийн хөгжлийн төвөөс санаачлан хамтран зохион байгуулж буй “Байгаль орчинд ээлтэй, тогтвортой тээвэр” сэдэвт Азийн бүс нутгийн Засгийн газар хоорондын дээд төвшний 11 дэх удаагийн форумын бэлтгэл ажлыг хангасан.

Монгол-Тяньжин эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны ажлын хэсгийн 8 дугаар хуралдааныг 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж ажилласан.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ